

“ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ ДАХЬ ДАВХАР ТАТВАРЫН ГЭРЭЭНИЙ БАЙР СУУРЬ БА ЭРХ ЗҮЙН ШИНЖ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Эрдэм шинжилгээний хурлын зорилго:

Энэхүү эрдэм шинжилгээний хурлын зорилго нь олон улсын гэрээний эрх зүйн онолын суурь зарчмуудын хүрээнд давхар татварын гэрээний эрх зүйн байр суурь, шинж, хэрэгжилтийн асуудлыг гүнзгийрүүлэн судалж, үндэсний хууль тогтоомж болон олон улсын эрх үүргийн уялдаа холбоог онол, практикийн түвшинд дүгнэхэд оршино.

Эрдэм шинжилгээний хурлын ач холбогдол:

Олон улсын гэрээний эрх зүйн онолын суурьт тулгуурлан давхар татварын гэрээний эрх зүйн байр суурь, хэрэгжилтийн онцлогийг онол, практикийн уялдаанд шинжилгээ хийж, Монгол Улсын татварын эрх зүйн бодлогыг олон улсын стандарт, хамтын ажиллагааны жишигт нийцүүлэхэд чиглэсэн шинэлэг эрх зүйн дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино.

Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцэх асуудлын хүрээ:

А. Нийтлэг асуудал, онолын үндэс, арга зүйн асуудал

- Олон улсын гэрээний эрх зүйн суурь зарчим, түүний татварын эрх зүйд үзүүлэх нөлөө;
- Давхар татварын гэрээг олон улсын гэрээний тусгай төрөл хэлбэрээр авч үзэх онолын үндэслэл;
- Давхар татварын гэрээний эрх зүйн шинж, бүтэц, хэрэгжилтийн суурь зарчмууд;
- Гэрээний хүчин төгөлдөр байдал, хэрэгжилт, тайлбар, зөрчлийн онолын асуудал;
- Гэрээний үүрэг биелүүлэх явц дах бүрэн эрхийн хязгаарлалтыг эрх зүйн талаас шинжлэх;
- Давхар татварын гэрээ ба үндэсний хууль тогтоомжийн зөрчил, нийцэл;
- Давхар татварын гэрээгээр бүрэлддэг олон улсын эрх зүйн харилцааны субъектүүдийн эрх, үүргийн зохицуулалт;
- Гэрээ ба дотоод хууль тогтоомжийн коллизийн зохицуулалтын эрх зүйн онцлог;
- OECD Model Convention ба UN Model Convention-ийн эрх зүйн ялгаа ба Монгол улсад хэрэглэх боломж;
- Давхар татварын гэрээний зөрчил, давхардлын практик тохиолдолдууд, маргаан шийдвэрлэх арга хэрэгсэл;
- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй давхар татварын гэрээнүүдийн эрх зүйн бүтэц, нийтлэг шинж;
- Монгол Улсын дотоод татварын хууль тогтоомж ба олон улсын гэрээний нийцлийн судалгаа;
- Давхар татварын гэрээний хэрэгжилтийн бодит практик /шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, татварын албаны туршлага/;
- Олон улсын гэрээний хэрэгжилтийн хяналт, тайлагнал, эрх зүйн хариуцлагын механизм.

Б. Хэрэглээ ба практик нөлөө

- Давхар татварын гэрээний эрх зүйн үр нөлөөг үнэлэх арга зүй;
- Монгол Улсын гэрээний эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх санал
- Судалгааны үр дүнг хууль зүйн боловсрол, бодлого боловсруулахад нэвтрүүлэх;
- Олон улсын гэрээний эрх зүйн онолын хөгжилд оруулах шинэлэг санаа, судалгааны хандлага,

Хуралд оролцогчид:

Хууль зүйн их сургуулийн эрдэмтэн, судлаачид, хууль зүйн салбарын мэргэжилтэн, ахисан түвшний сургалтын хөтөлбөрт суралцагсад.

Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах өдөр, газар

Эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 12 дугаар сарын 03 ний өдөр 09-12 цагийн хооронд Монголын Хуульчдын холбооны Хуульчдын танхимд зохион байгуулна.

Илтгэлийн бичлэгт тавигдах шаардлага:

- Хурлын зорилго, агуулгын хамаарах хүрээнд нийцсэн байна.
- Нэг буюу хамтран судлаачтай байж болно.
- Өмнө нь хурлаар хэлэлцүүлээгүй, нийтлэж хэвлээгүй шинэ судалгааны үр дүн байна.
- Илтгэлийг монгол, англи, орос хэлээр бичиж ирүүлж болно.
- илтгэл нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн агуулга, дүгнэлт, санал, ном зүй гэсэн хэсгээс бүтсэн, 8-10 хуудастай байна.
- Эшлэлийг АРА стандартаар хийж, зохиогчийн эрхийн зөрчилгүй байвал зохино

Мэдүүлэг, илтгэл хүлээн авах хугацаа.

Хуралд оролцогчдын мэдүүлэг, илтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор Gunbileg.work@gmail.com цахим шуудангийн хаягаар хүлээн авна.

Хугацаа хожимдсон, шалгуур хангаагүй илтгэлийг хүлээж авахгүй.

Илтгэгчдийн ирүүлсэн бүтээлийг хуулбарлалтын Turnitin программаар шалгаж, зохиогчийн эрхийг хамгаалах болно.

Мэдүүлгийг дараах загвараар ирүүлнэ.

- Овог нэр
- Илтгэлийн сэдэв
- Эрдмийн зэрэг, цол
- Ажлын газар
- Е-майл хаяг
- Холбоо барих утас

Эрдэм шинжилгээний хуралтай холбоотой мэдээллийг 95800707 дугаартай утсаар холбогдож авна уу.

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН,
БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХОРОО**